

АМГАЛАН ДУЛААНЫ СТАНЦ ТӨХК-ИЙН
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ М.МӨНХӨӨ



ТАМИРБУЛАГ ХХК-ИЙН
ЗАХИРАЛ П.ЦЭНД-АЮУШ



**ҮНС ТЭЭВЭРЛЭХ ШУГАМЫН КЕРАМИК ДОТОРЛОГООТОЙ БУЛАН ХУДАЛДАХ,
ХУДАЛДАН АВАХ ГЭРЭЭ**

20²³ оны 0⁵ сарын 3¹ өдөр

Дугаар 0²0³/73

Улаанбаатар хот

Нэг талаас “Амгалан дулааны станц” Төрийн өмчит хувьцаат компани /цаашид “Захиалагч” гэх/-ийг төлөөлж Гүйцэтгэх захирал М.Мөнхөө нөгөө талаас Тамир булаг ХХК-ийг төлөөлж захирал П.Цэнд-Аюуш /цаашид “Нийлүүлэгч” гэх/ нар Монгол Улсын Иргэний хуулийн 243-261 дүгээр зүйл, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.2 дахь заалт, 2023 оны худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг тус тус үндэслэн дараах зүйлүүдийг харилцан тохиролцож энэхүү гэрээг (цаашид “гэрээ” гэх) байгуулав.

Нэг. Гэрээгээр нийлүүлэх зүйл, нөхцөл

1.1 Нийлүүлэгч нь “Үнс тээвэрлэх шугамын керамик доторлогоотой булан ” (цаашид “бараа” гэх)-ыг энэхүү гэрээний салшгүй хэсэг болох хавсралтад заасан нэр төрөл, тоо хэмжээ, техникийн тодорхойлолтын дагуу захиалагчид нийлүүлнэ.

Хоёр. Бараа нийлүүлэх хугацаа

2.1 Нийлүүлэгч нь барааг гэрээнд хоёр тал гарын үсэг зурж баталгаажсанаас хойш 30 хоногийн дотор багтаан нийлүүлнэ.

Гурав. Үнэ төлбөрийн нөхцөл

3.1 Энэ гэрээний нийт үнэ 18,600,000 /арван найман сая зургаан зуун мянга/-н төгрөг бөгөөд үнийн дүнд гааль онцгой албан татвар, захиалагчийн агуулахад хүргэх тээврийн зардал, НӨАТ бүгд орсон байна.

3.2 Захиалагчаас нийлүүлэгчид урьдчилгаа төлбөр төлөхгүй.

3.3 Барааг хүлээлгэн өгсний дараа хүлээн авсан акт, гэрээ дүгнэсэн актыг үндэслэн 30 хоногийн дотор төлбөрийг нэхэмжлэлийн дагуу нийлүүлэгчийн Хаан банкны 5916076699 тоот дансанд шилжүүлнэ.

Дөрөв. Талуудын хүлээх хариуцлага

4.1 Нийлүүлэгч нь гэрээний үүргээ зохих ёсоор биелүүлээгүй, хугацаандаа нийлүүлээгүй барааны нийт үнийн дүнгийн 0.1 хувьтай тэнцэх алдангийг захиалагчид хоног тутам төлөх ба нийт алдангийн үнийн дүн гэрээний нийт үнийн дүнгийн 10% -иас хэтрэхгүй байна.

4.2 Захиалагч нь барааны бүрэн бүтэн байдал, техникийн үзүүлэлт, шаардлагад тохирч байгаа эсхийг шалган үзээд хүлээн авсны дараа гэрээнд заасан хугацаанд тооцоо хийх, төлбөрийн хугацааг хожимдуулбал хожимдсон хоног тутамд хүлээгдэж байгаа төлбөрийн 0.1 хувьтай тэнцэх алдангийг нийлүүлэгчид төлөх ба алдангийн дүн нь гэрээний хүлээгдэж байгаа төлбөрийн үнийн дүнгийн 10% -иас хэтрэхгүй байна.

4.3 Барааг захиалагчийн агуулахад ирсний дараа тус компанийн бараа хүлээн авах комисс шаардлага хангаж байгааг тогтоосон тохиолдолд барааг хүлээн авна. Барааг

Захиалагч:

1/4

Нийлүүлэгч:

шаардлага хангаагүй тохиолдолд буцаана. Буцаах зардлыг нийлүүлэгч бүрэн хариуцна.

- 4.4 Захиалагчийг төлөөлж гэрээний хэрэгжилттэй холбоотой асуудлыг Зуухан цехийн дарга Э.Ариунболд хариуцан ажиллана. Утас-99727172.
- 4.5 Нийлүүлэгчийг төлөөлж гэрээтэй холбоотой асуудлыг Тамир булаг ХХК-ийн захирал П.Цэнд-Аюуш хариуцан ажиллана. Утас- 99046071, 90908486
- 4.6 Нийлүүлэгч нь бараа хүлээлгэн өгөхдөө дараах баримт бичгийг бүрдүүлнэ. Үүнд:
- | | |
|---|--------|
| Бүтээц эд анги түүний иж бүрдэл чанарын гэрчилгээ | 3 хувь |
| Үйлдвэрлэгчийн техникийн дагалдах бичиг баримт | 3 хувь |

Тав. Бараа бүтээгдэхүүний чанар, сав, баглаа, боодол

- 5.1 Нийлүүлэгчийн нийлүүлэх бараа нь Олон Улсын болон Монгол Улсын стандарт шаардлагыг бүрэн хангасан байна.
- 5.2 Бараа нь тээвэрлэлт, хадгалалтын үед гэмтэхээс хамгаалсан сав, баглаа, боодолтой байна.
- 5.3 Барааг захиалагчид хүлээлгэн өгөх үед энэхүү гэрээгээр тодорхойлсон шинж чанарт нийцэж байвал зохих бөгөөд цаашид зориулалтын дагуу ашиглах хугацаанд чанараа алдахгүй байх ёстой.
- 5.4 Нийлүүлсэн бараанд ямар нэгэн дутагдал, шаардлагад нийцээгүй бараа илэрвэл дутагдлыг арилган, сольж өгөхийг захиалагч шаардах ба нийлүүлэгч шаардлагыг биелүүлэх үүрэгтэй.
- 5.5 Нийлүүлэгч нь нийлүүлсэн барааг ашиглаж эхэлсэн өдрөөс хойш /12/ арван хоёр сарын баталгаа гаргана. Баталгаат хугацаанд нийлүүлэгчийн үйл ажиллагаатай холбогдон гарсан чанарын асуудлыг өөрийн зардлаар засаж залруулах, сольж өгөх үүрэгтэй.

Зургаа. Бараа хүлээн авах

- 6.1 Нийлүүлэгч нь ачигдсан барааг захиалагчийн агуулахад хүргэн, ачааг буулгаж хүлээлгэн өгөх ба захиалагч талаас бараа хүлээн авах комисс хүлээн авна.
- 6.2 Нийлүүлэгч нь барааг захиалагчид хүлээлгэн өгөх хүртэлх бүх зардлыг хариуцна.

Долоо. Давагдашгүй хүчин зүйл

- 7.1 Гэрээг хэрэгжүүлэх явцад улс төрийн хориг, байгалийн гамшиг, хорио цээр тогтоох, цэргийн үймээн, төрийн эргэлт, ажил хаялт болон бусад нөхцөлүүд бий болсноос үүдэж гэрээний нөхцөлүүд хэсэгчлэн болон бүрэн биелээгүй тохиолдолд хоёр талын аль нь ч хариуцлага хүлээхгүй.
- 7.2 Давагдашгүй хүчин зүйлийн нөхцөлүүд гарч эхэлсэн тохиолдолд гэрээний хугацаа дуусахаас 10 хоногийн өмнө талууд бие биедээ бичгээр мэдээлж цаашид хэрхэн ажиллах талаар зөвшилцөнө.
- 7.3 Давагдашгүй хүчин зүйл гэдгийг зөвхөн Монголын Үндэсний Худалдаа Аж Үйлдвэрийн танхим батална.

Найм. Гэрээг цуцлах үндэслэл


- 8.1 Нийлүүлэгч нь барааг энэхүү гэрээний 2.1-т заасан материал нийлүүлэх хугацаанаас хэтрүүлсэн тохиолдолд Захиалагч гэрээг цуцлах тухай мэдэгдлийг Нийлүүлэгчид албан ёсоор бичгээр өгнө. Нийлүүлэгч уг мэдэгдлийг хүлээн авснаас хойш 10 хоногийн дотор зохих хариуг өгч тодорхой арга хэмжээ авахгүй тохиолдолд Захиалагч гэрээг цуцална.

Захиалагч:



2/4

Нийлүүлэгч:



8.2 Нийлүүлэгч энэхүү гэрээгээр хүлээсэн үүргээ ноцтой зөрчсөнөөс бусад тохиолдолд Захиалагч энэхүү гэрээний үйлчлэлийг дуусахаас өмнө тасалдуулахгүй.

Ес. Бусад нөхцөл

- 9.1 Талуудын аль нэг нь нөгөөдөө гэрээтэй холбогдох мэдээлэл солилцох тохиолдолд мэдээллийг авсан тал хуанлийн 7 хоногт багтаан нөгөө талдаа тавьсан асуудлаар тодорхой хариу өгнө.
- 9.2 Талууд аль нэгнийхээ зөвшөөрөлгүйгээр энэхүү гэрээг гурав дахь талд шилжүүлэхийг хориглоно.
- 9.3 Гэрээг монгол хэл дээр 3 хувь үйлдэж, Захиалагч 2 хувийг Нийлүүлэгч 1 хувийг авах бөгөөд хувиуд ижил тэгш хүчинтэй.
- 9.4 Гэрээг хоёр тал зөвшөөрсөн тохиолдолд 1 удаа сунгаж болно.
- 9.5 Гэрээнд хоёр тал гарын үсэг зурсан өдрөөс хүчин төгөлдөр байна.
- 9.6 Гэрээнд талууд харилцан тохиролцсоны үндсэн дээр бичгээр үйлдсэн гэрээний хэлбэрээр нэмэлт өөрчлөлт оруулж болох бөгөөд нэмж засварласан эх хувьд баллаж засварласан буюу гараар нэмж бичсэн болон бусад энгийн аргаар хийсэн оруулга засвар нэмэлт бичилтийг хүчинтэйд тооцохгүй.
- 9.7 Энэхүү гэрээнд шууд заагаагүй бусад аливаа асуудлыг Монгол улсын хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа хууль тогтоомжийн дагуу шийдвэрлэнэ.

ЗАХИАЛАГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

АМГАЛАН ДУЛААНЫ СТАНЦ ТӨХК-ИЙН

ЕРӨНХИЙ ИНЖЕНЕР



Э.МӨНХЖАРГАЛ

СЭЗХ-ИЙН ДАРГА
БӨГӨӨД ЕРӨНХИЙ
НЯГТЛАН БОДОГЧ



Ө.УДВАЛ

АЖ АХУЙ, ХАНГАМЖИЙН
ХЭЛТСИЙН ДАРГА



Г.БАТТУЛГА

ЗУУХАН ЦЕХИЙН
ДАРГА



Э.АРИУНБОЛД

ХУУЛИЙН
МЭРГЭЖИЛТЭН



Г.САРУУЛ

ГЭРЭЭ БОЛОВСРУУЛСАН :

ХАНГАМЖИЙН
МЭРГЭЖИЛТЭН



Ш.ГАНТУЛГА

НИЙЛҮҮЛЭГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

ТАМИР БУЛАГ ХХК-ИЙН

ЗАХИРАЛ



П.ЦЭНД-АЮУШ

Хаяг: Монгол улс, Улаанбаатар хот, Баянзүрх дүүрэг, 8-р хороо, УС-15-1-1
Утасны дугаар: 77111251
РД: 6021646


Хаяг: Монгол улс, Хөвсгөл аймаг, Мөрөн сум 9 байр
Утасны дугаар: 99065975, 96202101
РД: 4141067.

Захиалагч:



3/4

Нийлүүлэгч:



Тоот гэрээний хавсралт

Нийлүүлэх барааны жагсаалт

№	Бараа материалын нэр	Гарал үүсэл	Тип марк	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нэг бүрийн үнэ	Нийт үнэ
1	Керамик доторлогоотой булан	Хятад	Ду114 Ру20 М-200*С, 90*	ш	3	3,100,000	9,300,000
2	Керамик доторлогоотой булан	Хятад	Ду114 Ру20 М-200*С, 90*	ш	3	3,100,000	9,300,000
	НӨАТ-тай үнэ						18,600,000

Амгалан дулааны станц ТӨХК-ийн

Зуухан цехийн дарга

Э.Ариунболд



Тамир булаг ХХК-ийн

Захирал

П.Цэнд-Аюуш




Захиалагч



Нийлүүлэгч

